

ХӨГЖМИЙН УХААЛАГ САМБАРЫГ АШИГЛАХ ЗӨВЛӨМЖ


Хөгжмийн ухаалаг самбарыг сургалтад хэрэглэснээр багшийн арга зүйн ур чадварыг сайжруулж, суралцагчийн сурах идэвх оролцоо дээшилнэ.

Дэлхийн 50 гаруй оронд экспортлогдон BEST SELLER болж байгаа орчин үеийн шинэлэг техникийн үзүүлэлтүүдийг нэг дор багтаасан УХААЛАГ САМБАР нь Итали, Хятад улсын хамтарсан “Oves” компанийн бүтээл юм.

Ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн хичээлийн өнөөгийн хэв маягийг түргэн хугацаанд ахисан түвшинд гарган өөрчлөхөд нэн шаардлагатай, багшийн заах аргыг хялбарчилж, сурагчийн ойлгох чадварт оновчтой үр дүнтэйгээр нөлөөлж байгаа нь дэлхийн орчин үеийн хөгжмийн сургалтын заах аргачлалтай хөл нийлүүлэн алхахад хамгийн оновчтой сонголт болж чадна.

Ухаалаг самбар нь төгөлдөр хуур хөгжмийн 61 болон 88 даралтат хөгжмийг өөртөө суурилуулсан, зөөвөрлөхөд хялбар, чанга яригч бүхий, 150*200 см, 120*160 см-ийн 2 төрлийн хэмжээтэй бөгөөд эвхдэг хөлөн дээр байрлах ба мөн хананд тогтоох зориулалттай.

Самбар нь хэмнэл тохируулагчаас эхлээд олон үйлдэлтэй.



Зураг -1. Хөгжмийн ухаалаг самбар



Зураг -2. Ухаалаг самбарыг хананд байрлуулсан байдал

Самбарыг анги танхимын хананд байрлуулах нь хөгжмийн аюулгүй байдлыг хангахаас гадна багшийн самбартай ажиллахад хялбар байх болно. Өнөөгийн ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн хичээлийн сургалтад аккордион, төгөлдөр хуур, цахилгаан даралтат хөгжмүүдийг хэрэглэж байгаа нь 20-30 сурагчтай ангийн сурагч бүрт оновчтой, үр дүнтэй, хангалттай сургалт болон хүрч чадахгүй байгаа нь үнэн.



Зураг -3. Үлээвэр хөгжмийн хошуу

Бага ангийн сурагчдад хөгжмийн хичээлийг даралтат үлээвэр хөгжимтэйгээр хавсран заахад илүү үр дүнтэй болно. Энэ хөгжмийн зэмсгийг сургалтад хэрэглэснээр багшийн арга зүйн ур чадвар сайжирч суралцагчийн сурах идэвх оролцоо дээшилнэ гэж үзэж байгаа юм.

Үлээвэр хөгжмийн хошууг зөвхөн нэг сурагчид зориулан хэрэглүүлэх нь зөв юм. Энэ нь сурагчдыг ямарваа халдварт өвчин дамжих магадлал, эрсдлээс хамгаалах ач холбогдолтой.



Зураг -4. Үлээвэр хөгжмөөр хөгжимдөж болох байрлал

Даралтат үлээвэр хөгжмийг ширээн дээр байрлуулахаас гадна гар дээр тавьж тоглох боломжтой.

Хүүхдэд даралтат үлээвэр хөгжмийг анхлан заахдаа хурууны дугаар, амьсгалыг зөв авч сургах нь хамгийн чухал юм.




Зураг -5. Самбарын автомат удирдлага

Самбарын автомат удирдлага нь багшийн бичсэн нот, тоглосон хөгжмийг бичих, 180 төрлийн дуу, хэмжээг өөрөө хурдан удаан хэмнэлээр тоглох, компьютерт холбох MIDI оролт гаралт, нэмэлт чанга яригч залгаж болох INPUT OUTPUT оролт гаралтуудтай бөгөөд бүрэн хэмжээний мэргэжлийн сентизатор /keyboard/ хөгжмийн техникийн бүх үзүүлэлтүүдийг багтаасан байна.




Зураг -6. Самбарын автомат удирдлагатай холбох заагч

Самбар дээр бичсэн нотыг зааж дуу авиа гаргах заагч нь богино, мөн урт болон сунадаг. Мэдрэмтгий учир самбар дээр бичсэн нот дээр дарахад тухайн өнгө дуугарна. Заагчийн хошууг гэмтээхээс болгоомжлох нь зүйтэй.



Зураг -7. Самбарын автомат удирдлагатай холбох заагч


Самбар дээр бичсэн нотыг автомат удирдлагад холбосон заагчаар заахад бичсэн нотны дуу авиаг гаргах ба гурван өнгийн LED гэрэлт тэмдэгтээр шугаман дээрх нотны байрлалыг тодорхой харуулна.



Зураг -8. Зэргэлдээ мажор, миноруудын тэмдэглэгээтэй

Зэргэлдээ мажор, миноруудын хэдэн тэмдэгтэй, аль даралтууд хаана байрлах байрлалыг зориулалтын соронзон шугамын тусламжтайгаар тодорхой зааж өгнө.

Соронзон шугамыг багш төдийгүй сурагчид ашиглаж сурах хэрэгтэй. Самбар дээр соронзон шугамыг ажиллаж сургах нь сурагчдын хөгжмийн онолын мэдлэгийг бататгахад зайлшгүй шаардлагатай юм.



Зураг -9. Соронзон шугам

Мажор, минорын болон бүх аккордын бүтцийг соронзон шугамын туслалцаатай аль ч өнгөнөөс байгуулахыг тодорхой зааж өгнө. Энэ нь хөгжмийн онолын мэдлэгээ бататгахад ач холбогдолтой юм.

Соронзон шугамыг самбар дээр байрлуулж хадгалах, хөгжмийн ухаалаг самбарыг бага зэргийн чийгтэй, зөөлөн даавуугаар арчиж цэвэрлэхийг зөвлөж байна.

Боловсролын салбар ч ухаалаг хэрэглэгдэхүүн рүү алхаж байна. Үүний эхлэл болгосон хөгжмийн ухаалаг самбар, түүнийг дагалдагч пианика буюу үлээвэр даралтат хөгжим нь хүүхдийн хөгжмийн боловсролд тодорхой хэмжээгээр эерэг үр дүнгээ өгнө гэдэгт итгэлтэй байна.